



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/09

Арвайхээр сум


Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 5 дугаар багт иргэн М.Эрдэнэдалайн захиалгаар баригдсан 24 айлын орон сууцны барилга угсралтын ажил дууссан тул “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу дунд төвөгшилтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах Комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах Комиссын дарга (А.Энхцэцэг)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0019

Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дүгээр
сарын 10-ны өдрийн 1009 дугаар
захирамжийн хавсралт



**ДУНД ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: А.Энхцэцэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: С.Нямдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)

Г.Түвшинтөр (аймгийн Ерөнхий архитектор)

Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Б.Балжинням (аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч, Ахмад)

Б.Энхболд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хэмжил зүйн хяналтын улсын байцаагч)

Д.Чинзориг ("Онги-Ус суваг" ОНӨААТҮГ-ын ашиглалтын инженер)

М.Багаажав (Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Өвөрхангай аймаг дахь салбарын Ерөнхий инженер)

Г.Баасансүрэн ("Монголын мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн Өвөрхангай аймаг газрын кабель шугамын инженер)

Т.Гал-Эрдэнэ (Арвайхээр сумын Захирагчийн албаны Ерөнхий менежер)

А.Цэцэгмаа (Өвөрхангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл)

Н.Дудаарий ("Кон инженерс" ХХК-ийн инженер)

М.Эрдэнэдалай (орон сууцны барилгын захиалагч)

Ц.Энхтайван ("Тулгуурт оргил" ХХК-ийн инженер)

Нарийн бичгийн дарга: Ц.Нямдалай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)